



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/103/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2023 оны 02 дугаар сарын 13

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШШҮХ	Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.13 № 2/09

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 480 дугаар тогтоолоор Баянхонгор аймаг дахь Татварын хэлтэст бүртгэлтэй нийт 125,237.9 мянган төгрөгийн үнэ бүхий газар, барилга байгууламжийг балансаас балансад шилжүүлэн авснаар тус байгууллага нь өөрийн байртай болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Шүүх шинжилгээний хүрээлэнгээс 96.7 хувиар үнэлсэн

005020125

байна.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style, starting from the left and extending towards the right, crossing the stamp.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,084,504.00</u>	<u>2,842,230.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	4,084,504.00	2,842,230.00
351	Түүхий эд материал	95,860.00	1,770,130.00
35130	Эм боох материал	95,860.00	1,770,130.00
354	Хангамжийн материал	3,988,644.00	1,072,100.00
35410	Бичиг хэргийн материал	522,800.00	319,100.00
35420	Аж ахуйн материал	235,490.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	2,014,854.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	1,215,500.00	753,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29,730,656.39</u>	<u>111,245,725.96</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	29,730,656.39	111,245,725.96
392	Биет хөрөнгө	17,230,656.39	98,745,725.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	125,237,990.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-48,288,188.07
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,000,000.00	37,495,833.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,000,000.00	-37,495,833.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,047,213.00	51,319,562.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,860,876.76	-34,108,778.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,326,414.29	10,326,414.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,282,094.14	-5,741,274.18
393	Биет бус хөрөнгө	12,500,000.00	12,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,500,000.00	12,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>33,815,160.39</u>	<u>114,087,955.96</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>33,815,160.39</u>	<u>114,087,955.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	33,815,160.39	114,087,955.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	22,015,100.00	22,015,100.00
51101	Өмч: - төрийн	22,015,100.00	22,015,100.00
512	Хуримтлагдсан үр дүн	11,800,060.39	92,072,855.96
51210	Өмнөх үеийн үр дүн	11,800,060.39	11,800,060.39
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	80,272,795.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>33,815,160.39</u>	<u>114,087,955.96</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	178,907,300.00	296,905,197.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,655,500.00	93,753,897.73
120	Нийтлэг татварын бус орлого	7,655,500.00	93,753,897.73

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,485,500.00	5,863,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,485,500.00	5,863,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	171,251,800.00	203,151,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	167,823,800.00	197,574,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	167,823,800.00	197,574,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,428,000.00	5,576,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,428,000.00	5,576,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	177,602,198.27	216,573,902.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	177,602,198.27	216,573,902.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	176,491,949.90	213,583,016.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,765,416.07	146,421,599.35
210101	Үндсэн цалин	83,599,620.89	90,297,499.35
210102	Нэмэгдэл	45,460,340.80	42,082,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,705,454.38	11,373,200.00
210104	Урамшуулал	00.00	2,668,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,817,435.56	4,640,220.52
210201	Тэтгэврийн даатгал	1,503,817.66	1,040,216.96
210202	Тэтгэмжийн даатгал	183,361.60	190,199.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	146,689.29	152,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	49,347.51	38,099.76
210205	Эрүүл мэндийн даатгал	2,934,219.50	3,219,604.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,495,300.00	13,906,305.00
210301	Гэрэл, цахилгаан	1,550,000.00	1,144,235.00
210302	Түлш, халаалт	2,095,300.00	11,054,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,850,000.00	1,707,470.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,341,714.00	18,345,493.14
210401	Бичиг хэрэг	1,674,200.00	3,742,661.00
210402	Тээвэр, шатахуун	6,241,014.00	10,059,854.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,292,300.00	895,688.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	73,200.00	103,280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,061,000.00	3,544,010.00
2105	Нормативт зардал	6,037,940.00	12,847,130.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,058,240.00	12,347,330.00
210502	Хоол, хүнс	979,700.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	499,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	343,500.00	7,407,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	343,500.00	330,900.00
210604	Урсгал засвар	00.00	7,076,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	1,502,700.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,502,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,949,410.00	2,195,140.00

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,717,910.00	453,380.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	526,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,500.00	134,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	32,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	50,000.00	48,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,741,234.27	6,316,828.16
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,741,234.27	6,316,828.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,110,248.37	2,990,885.99
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,110,248.37	2,990,885.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,110,248.37	2,990,885.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,305,101.73</u>	<u>80,331,295.57</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	58,500.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	58,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-58,500.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,305,101.73</u>	<u>80,272,795.57</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>175,737,300.00</u>	<u>209,014,800.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,485,500.00	5,863,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,485,500.00	5,863,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,485,500.00	5,863,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,485,500.00	5,863,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	171,251,800.00	203,151,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	167,823,800.00	197,574,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	167,823,800.00	197,574,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,428,000.00	5,576,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,428,000.00	5,576,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>174,197,400.00</u>	<u>209,014,800.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	174,197,400.00	209,014,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	173,087,151.63	206,023,914.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,765,416.07	146,421,599.35
210101	Үндсэн цалин	83,599,620.99	90,297,499.35
210102	Нэмэгдэл	45,460,340.80	42,082,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,705,454.28	11,373,200.00
210104	Урамшуулал	00.00	2,668,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,817,435.56	4,640,220.52
210201	Тэтгэврийн даатгал	1,503,817.66	1,040,216.96

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210202	Тэтгэмжийн даатгал	183,361.60	190,199.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	146,689.29	152,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	49,347.51	38,099.76
210205	Эрүүл мэндийн даатгал	2,934,219.50	3,219,604.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,495,300.00	13,906,305.00
210301	Гэрэл, цахилгаан	1,550,000.00	1,144,235.00
210302	Түлш, халаалт	2,095,300.00	11,054,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,850,000.00	1,707,470.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,059,700.00	15,298,749.14
210401	Бичиг хэрэг	1,192,000.00	3,668,700.00
210402	Тээвэр, шатахуун	7,600,000.00	8,045,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,292,300.00	869,799.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	75,000.00	126,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	900,400.00	2,588,300.00
2105	Нормативт зардал	6,679,700.00	14,217,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,700,000.00	13,264,000.00
210502	Хоол, хүнс	979,700.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	953,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	350,000.00	7,373,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	350,000.00	297,200.00
210604	Урсгал засвар	00.00	7,076,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	1,502,700.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,502,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,919,600.00	2,663,140.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,688,100.00	921,380.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	526,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,500.00	134,460.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	32,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	50,000.00	48,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,110,248.37	2,990,885.99
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,110,248.37	2,990,885.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,539,900.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>1,539,900.00</u>	<u>00.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>1,539,900.00</u>	<u>00.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>1,539,900.00</u>	<u>00.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,539,900.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,539,900.00</u>	<u>00.00</u>

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	9,515,100.00	00.00	5,474,218.47	00.00	14,989,318.47
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,515,100.00	00.00	5,474,218.47	00.00	14,989,318.47
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,020,740.19	00.00	5,020,740.19
C08	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	22,015,100.00	00.00	11,800,060.39	00.00	33,815,160.39
D01	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	22,015,100.00	00.00	11,800,060.39	00.00	33,815,160.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	22,015,100.00	00.00	11,800,060.39	00.00	33,815,160.39
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	80,272,795.57	00.00	80,272,795.57
D09	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	22,015,100.00	00.00	92,072,855.96	00.00	114,087,955.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	201,074,600.00	200,447,214.01	627,385.99	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	201,074,600.00	200,447,214.01	627,385.99	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	201,074,600.00	200,447,214.01	627,385.99	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,421,600.00	146,421,599.35	0.65	100.0
210101	Үндсэн цалин	90,297,500.00	90,297,499.35	0.65	100.0
210102	Нэмэгдэл	42,082,400.00	42,082,400.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,373,200.00	11,373,200.00	0.00	100.0
210104	Урамшуулал	2,668,500.00	2,668,500.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,191,400.00	4,640,220.52	551,179.48	89.4
210201	Тэтгэврийн даатгал	1,306,200.00	1,040,216.96	265,983.04	79.6
210202	Тэтгэмжийн даатгал	190,200.00	190,199.76	0.24	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	152,100.00	152,100.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	38,100.00	38,099.76	0.24	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,504,800.00	3,219,604.04	285,195.96	91.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,913,900.00	13,906,305.00	7,595.00	99.9
210301	Гэрэл, цахилгаан	1,144,300.00	1,144,235.00	65.00	100.0

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
210302	Түлш, халаалт	11,054,600.00	11,054,600.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,715,000.00	1,707,470.00	7,530.00	99.6
2104	Хангамж, бараа материалын зардал	15,332,200.00	15,298,749.14	33,450.86	99.8
210401	Бичиг хэрэг	3,668,700.00	3,668,700.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	8,045,000.00	8,045,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	869,800.00	869,799.14	0.86	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,400.00	126,950.00	33,450.00	79.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,588,300.00	2,588,300.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	14,217,300.00	14,217,300.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,264,000.00	13,264,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	953,300.00	953,300.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,797,200.00	1,797,200.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	297,200.00	297,200.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,502,700.00	1,502,700.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	1,502,700.00	1,502,700.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,698,300.00	2,663,140.00	35,160.00	98.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	924,000.00	921,380.00	2,620.00	99.7
210803	Даатгалын үйлчилгээ	526,500.00	526,500.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,000.00	134,460.00	32,540.00	80.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,500.00	32,500.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	48,300.00	48,300.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	201,074,600.00	202,810,714.01	627,385.99	99.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	197,574,600.00	194,583,714.01	2,990,885.99	98.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	197,574,600.00	194,583,714.01	2,990,885.99	98.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Узүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,576,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,576,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,576,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,576,700.00
210604	Урсгал засвар	5,576,700.00

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,576,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,576,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,576,700.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Шүүх шинжилгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг, эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Шүүх шинжилгээний ерөнхий газрын харьяаны байгууллага юм.

Шүүхийн шинжилгээний алба нь шүүх эмнэлэг, криминалистик, бүртгэлийн хяналтын нэгж гэсэн бүтэцтэй 10 орон тоотой үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт 201,074.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны зорилго зорилт нь байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлэхэд оршино.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Б.Ганцэцэг (2022.01.01-2022.04.27), Б.Батдорж (2022.04.28-2022.12.31), 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ч.Батбилэг (2022.01.01-2022.08.14), Б.Гантулга (2022.08.15-2022.12.31) нар зурж, нярваар Д.Дэлгэрмаа ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн.
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны эхний 6 сарын үйл ажиллагаанд иж бүрэн хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/87 тоот тушаалаар баталсан “Хууль зүй дотоод хэргийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 114,087.9 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 80,272.8 мянган төгрөгөөр буюу 337.4 хувиар хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	4,084.5	2,842.2	(1,242.3)
Үндсэн хөрөнгө	29,730.6	111,245.7	81,515.1
Нийт хөрөнгө	33,815.1	114,087.9	80,272.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	33,815.1	114,087.9	80,272.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	33,815.1	114,087.9	80,272.8

Дээрх хүснэгтээс харахад, Бараа материалын дансны үлдэгдэл 2,842.2 мянган төгрөг болж өмнөх оноос 1,242.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 36,093.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, Баянхонгор

аймаг дахь Цагдаагийн газраас 58.5 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 37,394.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 111,245.7 мянган төгрөг болж 81,515.1 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 480 дугаар тогтоолоор Баянхонгор аймаг дахь Татварын хэлтэст бүртгэлтэй нийт 125,237.9 мянган төгрөгийн үнэ бүхий газар, барилга байгууламж, мөн ШШҮХ-ийн захирлын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” А/83 дугаар тушаалаар 21,495.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсантай тус тус холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 114,087.9 мянган төгрөг болж 80,272.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 80,272.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 197,574.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 3,500.0 мянган төгрөг, нийт зарлагыг 175,479.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 175,479.5 мянган төгрөг, зардлыг 22,095.1 мянган төгрөгөөр өсгөж, 197,574.6 мянган төгрөгөөр анх баталсан байна. Тайлант хугацаанд нэг удаа тодотгол хийж орлогыг 3,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 201.074.6 мянган төгрөг болгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 197,574.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 197,574.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогыг 7,940.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлж 5,576.7 мянган төгрөгийн зарцуулах эрх олгож, үйл ажиллагааны орлогын 2,363.5 мянган төгрөг, улсын төсвийн санхүүжилтийн 627.4 мянган төгрөг, нийт 2,990.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 200,447.2 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 627.4 мянган төгрөгөөр дутуу

зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70707 Шүүхийн шинжилгээ	201,074.6	200,447.2	627.4	99.7
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	200,150.6	199,525.8	624.8	99.7
3	82311 Шүүх шинжилгээний тусгай ажил үйлчилгээ	924.0	921.4	2.6	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай” 243 дугаар тушаалаар 5,576.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг урсгал засварын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12в/69 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 177,602.2 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 177,602.2 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 3,552.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,486.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 4 мэдээллийг байршуулаагүй, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 209,715.9 мянган төгрөгийн 14 гүйлгээ мэдээлэхээс 210,451.4 мянган төгрөгийн 9 гүйлгээ мэдээлж 735.5 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна. Мөн орлогын мөнгөн гүйлгээг бөөн дүнгээр мэдээлсэн байна.

Түүнчлэн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 5,576.7 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, мөн блэтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, мэдээллийг хугацаанд нь цахим хуудаст үнэн зөв дүнгээр байршуулах, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг байршуулж буйд тавих төсвийн шууд захирагчийн хяналтыг сайжруулах.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 40,000.0 мянган төгрөгийн албан шаардлагын дагуу Орон нутгийн өмчийн газартай авто машин ашиглалтын гэрээ байгуулж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	40,000.0	1	40,000.0	100
Нийт дүн	1	40,000.0	1	40,000.0	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,148.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрч дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлант хугацаанд бичиг хэрэг, хангамж, хөдөлмөр хамгааллын зардлаас 188.6 мянган төгрөгийн бараа материалыг нярвын тайлангаар орлого авч зарлагадалгүй шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5 дахь “бүх орлого”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авсан бараа материалыг нярвын тайланд орлого авч зарлагадах, цаашид худалдан авсан бараа материалыг шууд зардлаар тайлагнахгүй байх.

2. Тайлант хугацаанд 8 албан хаагчид албан томилолтоор ажиллаж байх хугацаанд нь 52 хоногийн хоолны зардалд 260.0 мянган төгрөгийг томилолтын зардалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тусгай чиг үүргийн байгууллагын хувьд албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны мөнгийг давхардуулан олгох эсэхийг НБББББ-т тодорхой тусгаж хэрэгжүүлэн төсвийн хөрөнгөд тавих хяналтаа сайжруулах.

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албаны автомашиныг орон нутгийн хөрөнгө оруулалтаар 36.0 сая төгрөгөөр батлагдсан байхад Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн албанд тус байгууллагын 2021.07.24-ний өдрийн 13в/210 тоот албан бичгээр ШШҮХ-ээс 4.0 сая төгрөгийн санхүүжилт гаргуулахаар шийдвэрлүүлсэн тул тендерийн үнэнд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлж 40,000.0 төгрөгөөр тендер зарласан байна. Орон нутгийн төсвөөс тендерт шалгарсан компанид 39.7 сая төгрөг буюу төсөвт өртгийг 3.7 сая төгрөгөөр хэтрүүлэн санхүүжүүлсэнд төлбөрийн акт тогтоосныг барагдуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн 3.7 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байгаа тул дээд шатны байгууллагад хандаж хөрөнгийг шийдвэрлүүлэн орон нутгийн орлогод төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Үүнээс																	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал							
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн						
Тайлант хугацаанд нийт 188.6 мянган төгрөгийн бараа материалыг няrvын тайлангаар орлого авч зарлагадалгүй шууд зардлаар тайлагнасан байна	1	188.6						1	188.6									
Тайлант хугацаанд 8 албан хаагчид албан томилолтоор ажиллаж байх хугацаанд нь хоолны зардал, томилолтын зардлыг давхардуулан олгосон байна.	1	260.0						1	260.0									
Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй байна.	1	3,700.0						1	3,700.0									
Дүн	3	4,148.6	0	0	0	0	0	3	4,148.6	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг 735.5 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.	1	735.5	0	0	0	0	735.5
Дүн	1	735.5	0	0	0	0	735.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	1	735.5	0	0	0	0	735.5

00000